



“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ О.ОТГОНБААТАР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2016. 04.12 № 3/621
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шивээ Овоо” ХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

“Шивээ Овоо” ХК-ийн удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

“Шивээ Овоо” ХК-ийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

- Тус компани нь уурхайн талбайг нөхөн сэргээх өнөөгийн үүрэг хариуцлагыг хуулиар хүлээсэн бөгөөд НББОУС 37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө стандартын дагуу өнөөгийн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд шаардагдах зарлагын тооцооллыг тооцоолоогүйгээс санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг тодорхойлох боломжгүй байна;
- Сангийн сайдын 2009 оны 135 дугаар тушаалыг үндэслэн 2009 онд үндсэн хөрөнгө түүхэн өртгөөр санхүүгийн тайланд тусгагдаж бодит үнэ цэнэ нь дансны үнээс ихээхэн ялгаатай болсон.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурьдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол "Шивээ Овоо" ХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С. ЭНХЗАЯА